

**ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 2016 ОНЫ III ДУГААР УЛИРЛЫН
ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Д/Д	Үзүүлэлт	Тоон мэдээлэл		
1	Захзээлийн (төгрөгөөр) үнэлгээ	1,387,687,323,298		
2	ЗЗҮ/ДНБ (хувиар)	8.03% (1,387,687.3/17,258,900)		
3	Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо			
	Үнэт цаас гаргагчийн өмчийн хэлбэр	Санхүүгийн зохицуулах хороо /302/	“Монголын хөрөнгийн бирж” ХК /228/	“ҮЦТХТ” ХХК /313/
	100% төрийн өмчит	30	19	44
	Төрийн өмчийн оролцоотой	15	15	
	Хувийн өмчит	192	194	269
	Хорооны 2013 оны 278, 500 дугаар тогтоолоор МХБ-ийн бүртгэлээс хассан ХК-ийн тоо:	65	-	-
	100% төрийн өмчит	1	-	-
	Төрийн өмчийн оролцоотой	4	-	-
	Хувийн өмчит	60	-	-
4	Зах зээлийн үнэлгээ өндөр компаниуд			
	№	Үнэт цаасны нэр	ЗЗҮ (тэрбум төгрөг)	
	1	АПУ	295.50	
	2	МИК ХОЛДИНГ	217.44	
	3	ТАВАН ТОЛГОЙ	100.96	
	4	ГОВЬ	75.98	
	5	БАГАНУУР	63.60	
	6	СҮҮ	46.99	
	7	УБ БҮК	39.46	
	8	ШИВЭЭ ОВОО	35.29	
	9	МОНГОЛ ШУУДАН ХК	28.83	
	10	БИДИСЕК	28.56	
	11	ГУТАЛ	27.35	
	12	МОНГОЛ СЕКЮРИТИЕС	26.70	
	13	ТАХЬ-КО	25.99	
	14	ШАРЫН ГОЛ	25.93	
	15	ДАРХАН НЭХИЙ	22.11	
	16	ТАЛХ ЧИХЭР	20.06	
	17	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	17.75	
	18	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	16.08	
	19	МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	15.78	
	20	БЭРХ УУЛ	15.34	
	21	ХАЙ БИ ОЙЛ	12.87	
	22	МАТЕРИАЛ ИМПЕКС	12.64	
	23	АТАР-ӨРГӨӨ	10.80	
	24	ГЕРМЕС ЦЕНТР	10.60	
	25	СИЛИКАТ	10.43	
	26	МАХ ИМПЕКС	10.26	
	27	ТЕХНИК ИМПОРТ	7.71	

Comment [E1]: МХБ

Comment [E2]: СЗХ, ХШЗГ

Comment [E3]: МХБ

	28	АРИГ ГАЛ	7.65		
	29	ЖЕНКО ТУР БЮРО	6.50		
	30	МОНГОЛ ШИЛТГЭЭН	6.40		
5	Индекс	<i>Дундаж</i>	<i>Хамгийн их</i>	<i>Хамгийн бага</i>	<i>Хаалт</i>
		TOP-20Index	12,229.03	12,939.50	11,293.28
		MSE-ALL Index	859.85	894.94	814.08
6	Дансны мэдээлэл(шинээр нээгдсэн)				
		<i>Монгол</i>	Иргэн	879,510	
			ААН	2,517	
		<i>Гадаад</i>	Иргэн	1,905	
			ААН	179	
		Нийт (өссөн дүнгээр)		830,138	
		Холболтын данс		136,854	
7	Хувьцааны арилжаа	Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт 184 удаагийн хувьцааны арилжаагаар 228 үнэт цаас нь бүртгэгдсэн компанийн 19.5 сая ширхэг хувьцааг 39.5 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна.			
8	ЗГҮЦ арилжаа	<i>Үнийн дүн</i>	<i>Тоо, ширхэг</i>		
		Анхдагч	102,816,348,901	1,102,558	
		Хоёрдогч	7,919,289,820	80,350	
9	Анхдагч зах зээлийн арилжаа	“Монгол Шуудан” ХК-ийн 33 сая ширхэг хувьцааг 6 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна.			
10	Компанийн бонд	-			
11	Хувьцааны арилжаа	<i>Дүн(төгрөгөөр)</i>	<i>Хувь</i>		
		Гадаад	46,156,430,532.6	97,3%	
		Дотоод	1,280,805,369.4	2,7%	
		<i>Нийт</i>	47,437,235,902	100%	
12	Арилжааны төлбөр, тооцоо	<i>Нийт орлого (төгрөгөөр)</i>		165,699,527.08	
		<i>Нийт зарлага (төгрөгөөр)</i>		160,496,500	
13	Төлбөр гүйцэтгэгч банкууд (сая төгрөгөөр)	<i>Дүн</i>	<i>Хувь</i>		
		Голомт	3,434.0	30,21%	
		Хаан	64.9	5,71%	
		Хас	5,179.9	45,57%	
		ХХБ	2,678.6	23,57%	
		<i>Нийт</i>	11,366.4	100%	
14	Хөрөнгийн зах зээлийн нийт оролцогчид (давхардсан тоогоор)				
	Хөрөнгө оруулалтын зөвлөхийн		15		
	Андеррайтерийн		26		
	Төлбөр гүйцэтгэгч банк		5		
	Кастодиан банк		3		
	Брокер, дилер		62		
	Хөрөнгө оруулалтын менежментийн		12		
	Харилцагчийн нэрийн өмнөөс зуучлалын		1		
	Үнэт цаасны хадгаламжийн		1		
	Үнэт цаасны төлбөр, тооцоо		1		
	Үнэт цаасны арилжаа эрхлэх		2		
15	ҮЦТХТ-д хадгалагдаж буй үнэт цаас (мянган ширхэгээр)				
	1. Бүртгэлтэй үнэт цаас				

Comment [E4]: МХБ

Comment [E5]: ҮЦТХТ

Comment [E6]: МХБ

Comment [E7]: МХБ

Comment [E8]: МХБ

Comment [E9]: МХБ

Comment [E10]: АТТ

Comment [E11]: АТТ

Comment [E12]: СЗХ

Comment [E13]: ҮЦТХТ


	Төрийн мэдлийн бус хувьцаа	2,472,207
	Төрийн мэдлийн хувьцаа	4,520,597
	Орон нутгийн оролцоотой	29,046
	<i>Нийт</i>	<i>7,021,850</i>
	Засгийн газрын бонд	2,476
	Компанийн бонд	233.0
	<i>Нийт бондын тоо</i>	<i>2,709</i>
	<i>2. Биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаас</i>	
	Компанийн бонд	22,399
	Засгийн газрын бонд	2,250
	<i>Нийт бондын тоо</i>	<i>24,649</i>
	Эрдэнэс Тавантолгой /Иргэн/	2,212,223
	Эрдэнэс Тавантолгой /ААН/	5,167
	Эрдэнэс Тавантолгой /Төр/	12,782,611
	<i>Нийт</i>	<i>15,000,000</i>
	Хаалттай ХК	174,958
	<i>Нийт</i>	<i>174,958</i>

Дээрх үзүүлэлтүүдийг графикаар илэрхийлбэл:

1. Зах зээлийн үнэлгээ

2016 оны 3 дугаар улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 1,387.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 97.8тэрбум төгрөг буюу 7.58 хувиар өсчээ.


Дүрслэл1. Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөгөөр)



2. Зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ), Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ), хөрвөх чадвар

2011 оноос хойшхи хугацаанд ЗЗҮ/ДНБ-ий харьцаа тасралтгүй буурах хандлагатай байсан бол 2016 оны III улирлын байдлаар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл2. ЗЗҮ, ДНБ, хөрвөх чадвар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо

3. Үнэт цаасны зах зээлийн индексүүд

Тайлант хугацаанд ТОП-20 индекс өмнөх оны үетэй харьцуулахад 6.85 хувиар буурч, 11,433.16 нэгжид байгаа бөгөөд индексийн дээд үзүүлэлт 12,939.5, доод үзүүлэлт 11,293.28, дундаж үзүүлэлт 12,229.03 нэгж байна.

MSE ALL индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.27 хувиар буурч, 820.9 нэгжид хүрчээ. Тус индексийн дээд үзүүлэлт 894.94 нэгж, доод үзүүлэлт 814.08 нэгж, дундаж үзүүлэлт 859.85 нэгжтэй гарлаа.


Дүрслэл 3. ТОП-20 индекс



4. Үнэт цаасны зах зээлийн оролцогчид

Тайлант хугацаанд Хорооны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 302 компани бүртгэлтэй байна.


Дүрслэл 4. Хувьцаат компанийн тоо



5. Хадгаламж өмчлөх эрх бүртгэл, кастодианы үйл ажиллагаа

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжинд 2016 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 316 ХК-ийн 1,4 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий 22,191,249,701 ширхэг үнэт цаас хадгалагдаж байгаагаас нээлттэй 312 ХК-ийн 7,021,850,337 ширхэг хувьцаа, төрийн өмчтэй 34 ХК-ийн 2,818,123,684 ширхэг хувьцаа, орон нутгийн өмчтэй 9 ХК-ийн 29,045,916 хувьцаа байна. Хаалттай ХК-ийн бүртгэлд 4 ХК-ийн 15,174,957,700 ширхэг хувьцаа хадгалагдаж байгаагаас төрийн өмчийн 1 ХК-ийн 12,782,610,659 ширхэг хувьцаа байна.

Дүрслэл5. Төр, орон нутгийн өмчтэй болон төрийн мэдлийн бус хувьцааны харьцаа



Төвлөрсөн хадгаламжид хадгалагдаж буй үнэт цаас			
Үзүүлэлт	/мянган ширхэгээр/		
	2014 он	2015 он	2016 оны III улирал
1. Бүртгэлтэй үнэт цаас			
Төрийн мэдлийн бус хувьцаа	2,913,776	2,809,930	2,472,207
Төрийн мэдлийн хувьцаа	2,254,152	2,246,316	4,520,597
Орон нутгийн оролцоотой	29,046	29,046	29,046
Нийт хувьцаа	5,196,974	5,085,292	7,021,850
Засгийн Газрын бонд	2,510	2,415	2,476
Компанийн бонд	233.0	283.0	233.0
Нийт бондын тоо	2,743	2,698	2,709
2. Биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаас			
Компанийн бонд	8,402	20,668	22,399
Засгийн Газрын бонд	2,512	2,314	2,250
Нийт бондын тоо	10,914.1	22,982	24,649
Эрдэнэс Тавантолгой /Иргэн/	967,134	2,558,176	2,212,223
Эрдэнэс Тавантолгой /ААН/	4,915	5,139	5,167
Эрдэнэс Тавантолгой /Төр/	14,027,951	12,436,685	12,782,611
Нийт	15,000,000	15,000,000	15,000,000
Хаалттай ХК	-	172,753	174,958
Нийт		172,753	174,958

Эх сурвалж: "ҮЦТХТ" ХХК

Төвлөрсөн хадгаламжид төрийн мэдлийн нийт 35 ХК-ийн 15,5 тэрбум ширхэг хувьцаанаас МХБ-д бүртгэлтэй 34 ХК-ийн 4,689,997 ширхэг хувьцаа, биржийн бус зах зээлд бүртгэлтэй 1 ХК-ийн /Эрдэнэс Тавантолгой ХК/ 12,436,694,180 ширхэг хувьцаа, 22 төрлийн 22,632,358 ширхэг компанийн бонд, 106 төрлийн 2,476,084 ширхэг Засгийн газрын бонд тус тус бүртгэлтэй байна. Үүнээс 18 төрлийн 22,399,394 ширхэг Компанийн бонд, 61 төрлийн 2,249,900 ширхэг Засгийн газрын бонд нь биржийн бус зах зээл буюу хаалттай хэлбэрээр бүртгэгдсэн байна.


2014 онд СЗХ-ноос батлагдсан Хаалттай ХК-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагааны журмын дагуу 3 хаалттай ХК-ийн 174,957,700 ширхэг хувьцаа бүртгэлтэй байна. Үүнд:

№	Хаалттай ХК-ийн нэр	Хувьцааны тоо ширхэг
1	Хөдөө аж ахуйн давхар даатгал	150,000,000
2	Ард санхүүгийн нэгдэл	22,752,700
3	Апи ресурс	2,205,000

Дээрхи 313 ХК-ийн 22,021,850,337 ширхэг үнэт цаасны тоо ширхэгээр нь авч үзвэл:

Төрийн өмчийн оролцоотой хувьцаа 15,535,007,343 ширхэг буюу нийт хувьцааны 70.5%-ийг, орон нутгийн оролцоотой хувьцаа 29,045,916 ширхэг буюу нийт хувьцааны 0.13%-ийг, төрийн мэдлийн бус хувьцаа 6,457,797,078 ширхэг буюу нийт хувьцааны 29.3%-ийг тус тус эзэлж байна.

Дүрслэлб. Хадгалагдаж буй үнэт цаасны төрөл



Хөрөнгө оруулагчдын хувьд ХК-ийн 5-аас дээш хувийг эзэмшигч нийт 1,037 хувьцаа эзэмшигчийн эзэмшилд 6.7 тэрбум ширхэг хувьцаа төвлөрсөн байна. Энэ нь нийт бүртгэлтэй хувьцааны 30.56%-ийг эзэлж байна.

Үнэт цаасны бүртгэлийг онуудаар харьцуулан үзвэл:

Төвлөрсөн хадгаламжид хадгалагдаж буй хувьцаат компаниудын судалгаа

Он	Нийт үнэт цаасны тоо	Үүнээс		Шинээр бүртгэгдсэн үнэт цаас	Хадгаламжаас хасагдсан	МХБ-ийн бүртгэлээс хасагдсан
		Төр болон ОН-ийн өмчийн оролцоотой	Бүрэн хувьчлагдсан			
2012	339	49	290	1	2	0
2013	329	45	284	0	10	57
2014	323	45	278	2	2	0
2015	321	46	273	2	4	0
2016 оны III улирал	313	44	269	0	1	0

Шинээр бүртгэсэн:

- 3 дугаар улирлын байдлаар Сангийн яам, Монгол банкны ерөнхийлөгчийн хамтарсан тушаалын дагуу батлагдсан Засгийн газрын үнэт цаас арилжаалах журмын дагуу 28 төрлийн 655,000 ширхэг хаалттай ЗГҮЦ-ыг бүртгэсэн.
- МХБ-ээр арилжаалах 35 төрлийн 3,459,480 ширхэг нээлттэй ЗГҮЦ-ыг бүртгэсэн.
- СЗХ-ны 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 2 тогтоолын дагуу “МИК Актив Найм” ХХК-ийн 1,898,404 ширхэг бонд бүртгэсэн.
- СЗХ-ны 2016 оны 04 дүгээр 06-ны өдрийн 97 тогтоолын дагуу “МИК Актив Ес” ХХК-ийн 1,375,483 ширхэг бонд бүртгэсэн.

Үнэт цаасны тоо ширхэг нэмсэн, хассан, нэр өөрчилсөн:

- СЗХ-ны 2013 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 37 тоот тогтоолын дагуу “Улаан Сан” ХК-ийн 24,871 ширхэг хувьцааг хассан.
- 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар үндсэн ба хүүгийн төлбөр төлөгдсөн “МИК Актив Нэг” бондоос 135,161 ширхэг, “МИК Актив Хоёр” бондоос 47,793 ширхэг, “МИК Актив Гурав” бондоос 66,971 ширхэг, “МИК Актив Дөрөв” бондоос 85,260 ширхэг, “МИК Актив Тав” бондоос 98,125 ширхэг, “МИК Актив Зургаа” бондоос 47,610 ширхэг, “МИК Актив Долоо” бондоос 98,637 ширхэг, “МИК Актив Найм” бондоос 31,820 ширхэг, “МИК Актив Ес” бондоос 14,063 ширхэгийг тус тус хасаж, үндсэн бүртгэлд өөрчлөлт оруулсан.

Бүртгэлээс хассан ХК, ЗГҮЦ, Компанийн Бонд:

Бүртгэлээс хасагдсан ХК:

№	Бүртгэлээс хасагдсан ХК	Тоо ширхэг	Шийдвэр
1	“Буудайн цацал” ХК	72,076	СЗХ-ны 2015.11.23-ны 384 тогтоол, МХБ-ийн 2016.06.22-ны 146 тоот мэдэгдэл

Бүртгэлээс хасагдсан Засгийн Газрын Бонд:

№	Нээлттэй бонд	Төрөл	Хасагдсан бондын ширхэг
---	---------------	-------	-------------------------

1	I улирал	15	1,222,737
2	II улирал	12	1,299,768
3	III улирал	11	706,895
№	Хаалттай Бонд	Төрөл	Хасагдсан бондын ширхэг
1	I улирал	12	310,000
2	II улирал	12	394,000
3	III улирал	10	220,000

Бүртгэлээс хасагдсан Хөрөнгөөр баталгаажсан Бонд:

СЗХ-ны 2016 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 110 тоот тогтоолын дагуу “МИК ОСКК” ХХК-ийн 6 төрлийн 22,100 ширхэг Хөрөнгөөр баталгаажсан бондын үлдэгдлийг төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасав.


Хадгаламжийн гэрээ: 2016 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 13 ХК-тай хадгаламжийн гэрээ байгуулж, 48,429,485 төгрөгийн үйлчилгээний хөлс тооцсон.

6. Үнэт цаасны өмчлөх эрх, бүртгэл

Үнэт цаасны хоёрдогч зах зээл эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 830,138 данс, 136,854 холболтын данс нээгдсэн байна.

Нийт нээгдсэн данснаас 879,510 нь дотоодын иргэн, 1,905 гадаадын иргэн, 2,517 дотоодын аж ахуйн нэгж, 179 гадаад аж ахуйн нэгжийн данс нээгдсэн байна.

Дүрслэл7. Шинээр нээгдсэн данс



Шинээр нээгдсэн дансны харилцагчдын төрөл

Он	Иргэн		ААН	
	Монгол	Гадаад	Монгол	Гадаад
2016-III улирал	70,573	43	35	2

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа /2016 оны 2 дугаар улирлын байдлаар/

Тайлант улиралд “МИК ОССК” ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гараагүй байна. Хорооны 2016 оны 97 дугаар тогтоолоор “МИК Актив Ес” ХХК-ийн 1,375,483 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн ба 2016 оны 2 дугаар улирлын байдлаар өссөн дүнгээр 9 удаагийн үнэт цаасжуулалт хийгдсэнээс нийт 220.8 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр төлөгдсөн.

ХБҮЦ гаргагч	Нийт гаргасан үнэт цаас	"ҮЦТТХТ" ХХК-д бүртгэгдсэн	Зээлдэгчийн тоо	2016.3.30-ний үлдэгдэл
“МИК активнэг ТЗК” ХХК	328.1	322.9	6,658	328.1
“МИК активхоёр ТЗК” ХХК	224.8	222.1	5,290	224.8
“МИК активгурав ТЗК” ХХК	328.5	324.6	6,593	328.5
“МИК активдөрөв ТЗК” ХХК	459.4	452.3	9,510	459.4
“МИК активтав ТЗК” ХХК	301.2	294.3	5,805	301.2
“МИК активзургаа ТЗК” ХХК	267.8	261.7	5,188	267.8
“МИК активдолоо ТЗК” ХХК	299.6	293.8	5,414	299.6
“МИК актив найм ТЗК” ХХК	189.8	186.3	3,291	189.8
“МИК актив ес ТЗК” ХХК	137.5	137.2	1,719	137.5
Нийт	2,536.7	2,495	49,468	2,536.7

“МИК ОССК” ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах хүрээнд тусгай зориулалтын компаниудыг үүсгэн байгуулж, Хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, хөрөнгө итгэмжлэн удирдах зөвшөөрөл авсан бөгөөд 2015 онд “МИК ОССК” ХХК нь олон нийтэд 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,709,320 ширхэг үнэт цаасыг санал болгож, нээлттэй ХК болсон. ХБҮЦ-ны 90 хувийг Монголбанк, үлдсэн 10 хувийг ипотекийн зээлийн багц хөрөнгөө худалдсан банкууд эзэмшиж байна.

2016 оны 3 дугаар улирлын байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөлтэй 62 брокер, дилер /үнэт цаасны компани/-ийн компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн санхүүгийн үйл ажиллагааны нөхцөл байдал дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Мэргэжлийн оролцогчид

№	Тусгай зөвшөөрөл	Тоо
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
2	Үнэт цаасны төлбөр тооцоо	1
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	7
5	Брокер, дилерийн	62
6	Кастодиан банк	3
7	Давхардсан тоогоор андеррайтерийн	26
8	Давхардсан тоогоор хөрөнгө оруулалтын зөвлөхийн	15
	НИЙТ	76

Тайлант хугацаанд 50 үнэт цаасны компани /ҮЦК/ Хорооны санхүүгийн тайлагналын Фин-А системд тайлангаа ирүүлснээр салбарын нэгтгэлийг гаргасан бөгөөд дээрх ҮЦК-уудын санхүүгийн байдлын тайланг хураангуй хэлбэрээр харуулвал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 2. Нийт хөрөнгийн бүтэц /төгрөг/

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлант үе
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	50,629,441,813.89
2	Эргэлтийн бус хөрөнгө	20,815,441,726.80
3	Нийт актив	71,444,883,540.69
4	Өр төлбөр	11,645,564,988.60
5	Эздийн өмч	59,799,318,552.08
6	Нийт пассив	71,444,883,540.69

Салбарын нэгтгэлд хамрагдсан ҮЦК-уудын нийт актив тайлант үеийн байдлаар 71.4 тэрбум төгрөг байгаагаас 70.8 хувийг эргэлтийн хөрөнгө, 29.2 хувийг эргэлтийн бус хөрөнгө тус тус эзэлжээ. Нийт пассивын 16.3 хувийг өр төлбөр, 83.7 хувийг эздийн өмч тус тус эзэлж байна. Нийт өрийг бүтцээр нь үзвэл, богино хугацаат өр төлбөр 96.2 хувь, урт хугацаат өр төлбөр 3.8 хувийг тус тус эзлэж байна.

Хүснэгт 3. Орлогын бүтэц /төгрөг/

№	Орлогын хураангуй тайлан	Тайлант үе
1	Үйл ажиллагааны орлого	3,438,131,229.69
2	Ногдол ашгийн орлого	438,297,103.64
3	Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал	4,655,255,344.64
4	Ажиллагчдын цалингийн зардал	2,136,909,754.06
5	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	651,136,165.44
6	Санхүүгийн зардал	253,024,067.82
7	Бусад зардал	42,999,183.34
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	330,132,499.96
9	Бусад ашиг (алдагдал)	-1,359,173,153.03
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-969,368,832.40
11	Орлогын татварын зардал	88,829,704.51
12	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,058,198,536.91
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,058,198,536.91
14	Бусад дэлгэрэнгүй орлого	3,098.17
15	Орлогын нийт дүн	-1,058,198,536.91

2016 оны 3 дугаар улирлын байдлаар санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдсан 50 ҮЦК-иас нэр бүхий 34 ҮЦК буюу 68 хувь нь алдагдалтай ажилласан, нэр бүхий 13 ҮЦК огт арилжаанд оролцоогүй, шимтгэлийн орлого олоогүй тул түрээсийн болон ашиглалтын зардал зэрэг тогтмол шинжтэй үйл ажиллагааны зардлуудаас хамааран алдагдалтай ажиллаж байна.

Иймээс үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэхэд шалгалт хийж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаж чадах эсэхэд дүн шинжилгээ хийж, ҮЦК-уудыг хөрөнгөжүүлэх, нэгтгэх, нийлүүлэх зэрэг бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Энэ хүрээнд Хорооны 2016 оны 94 дүгээр тогтоолоор үнэт цаасны зах зээл дэх зарим зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг дараах байдлаар өөрчилсөн. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа 10.0-30.0 сая,

- Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа 50.0-100.0 сая,
- Үнэт цаасны дилер 50.0-200 сая,
- Андеррайтер 200.0-1.000 сая г.м

Мөн эдийн засгийн хүндрэлтэй өнөөгийн нөхцөлд салбарын оролцогчдын үйл ажиллагааг дэмжихийн тулд үнэт цаасны арилжааны шимтгэлийн хэмжээг богино хугацаанд бууруулах бодлого барих шаардлагатай.